



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 79

Номгон

Хөрөнгийн тухай


Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Нийтийн номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10 нэрийн 5208020 төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн актлах хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар, Эрдэнэмандал ахлах сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1977 онд ашиглалтад орсон 3253690 төгрөгийн анхны үнэтэй, элэгдлээ 100 хувь нөхсөн агуулахын модон барилгыг тус тус акталж данснаас хассугай.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу дуудлагаар худалдсан Баянлиг сумын хуучин дотуур байрны барилгын үлдэгдэл үнэ 41,5 сая төгрөгт багтааж 1м^2 –ын үнийг 600,0 мянган төгрөгөөр тооцож тус сумын Засаг даргын Тамгын газар, ахлах сургууль, Эрүүл мэндийн төвд тус бүр нэг өрөө байр, Эрдэнэмандал ахлах сургуулийн аж ахуйн аргаар шинээр барьж байгаа агуулахын барилгуудын эх үүсвэрийг тус тус орон нутгийн орлогоор хүлээн зөвшөөрч байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

3. Орлого авсан, акталсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоослын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.


ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D;2016-togtool2016

11679



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны
79 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ ЛОНОНГ ТӨХӨӨРӨМЖ

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Тайлбар
1	Баянхонгор	Нийтийн номын сан	Ном тоослогч	2009.01.1	3	9000.00	27000.00	27000.00	0.00	
2	Баянхонгор	Нийтийн номын сан	Дрож уншлагын танхимын	2009.01.01	9	26100.00	234900.00	234900.00	0.00	
3	Баянхонгор	Нийтийн номын сан	Дарга ширээ сандал	2009.01.01	1	1170000.00	1170000.00	1170000.00	0.00	
4	Баянхонгор	Нийтийн номын сан	Дижитал аппарат	2009.01.01	1	529020.00	529020.00	529020.00	0.00	
5	Баянхонгор	Нийтийн номын сан	Ус буцалгагч	2009.01.01	1	48600.00	48600.00	48600.00	0.00	
6	Баянхонгор	Нийтийн номын сан	Тоос сорогч	2009.01.01	1	90000.00	90000.00	90000.00	0.00	
7	Баянхонгор	Нийтийн номын сан	Варкод уншигч	2009.01.01	1	931500.00	931500.00	931500.00	0.00	
8	Баянхонгор	Нийтийн номын сан	Номын сангийн ширээ	2009.01.01	10	43706.00	437060.00	437060.00	0.00	
9	Баянхонгор	Нийтийн номын сан	Номын сангийн сандал	2009.01.01	20	28097.00	561940.00	561940.00	0.00	
10	Баянхонгор	Нийтийн номын сан	Том конан	2010.12.25	1	1178000.00	1178000.00	1178000.00	0.00	
							5208020.00	5208020.00	0.00	



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 80

Номгон

Гэрээнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтзолын дагуу Баянлиг, Бууцагаан сумдын төсөвт байгууллагад ашиглагдаж байсан хуучин барилгуудыг дуудлагаар худалдаж, зээлээр худалдах, худалдан авахаар байгуулсан гэрээнд хугацааг сунгах заалт ороогүй тул гэрээний хугацааг сунгах заалт оруулсугай.

2. Дуудлагаар худалдсан барилгуудын үлдэгдэл үнийг гэрээнд заасан хуваарийн дагуу барагдуулан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 81

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Богд сумын нутаг орших Их богд хайрханыг төрийн тахилгатай болгох талаар судалж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Отгонбаяр - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Нарийн бичгийн дарга: С.Үнэнбуян - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүд: Ламын гэгээний 8 дугаар дүр Данзанжамбалчойжишинэн

Т.Галсан – Монгол Улсын Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн

С.Дулам – Эрдэмтэн, доктор МУИС-ын Нүүдлийн иргэншил судлалын төвийн эрхлэгч

Б.Баянжаргал – Ламын гэгээний Гон гандан дэдлин хийдийн хамба

Ш.Алтанбагана – Улаанбаатар хот дах Баянхонгор аймгийн Нутгийн зөвлөлийн дарга

Д.Ганболд – Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Б.Ганзориг – Баянхонгор аймгийн Оюутан залуучуудын нэгдсэн холбооны ерөнхийлөгч

Ж.Алтанцэцэг – Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,
Тэргүүлэгч

Б.Бат-Өлзий – Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Т.Мөнхсэргэлэн – Хонгор нутгийн хөгжлийн төлөө төвийн захирал

Ч.Очирбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Содномсамдан – Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн

Дан.Нямаа – Монголын радиогийн ерөнхий редактор

2. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг 2016 оны 12 дугаар сарын 05–ны дотор
аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхийг
ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



ЦОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 82

Номгон

Ахмадын зөвлөл байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд орон тооны бус Ахмадын зөвлөл байгуулсугай.
2. Ахмад зөвлөхүүдийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.
3. Зөвлөлийн ажиллах журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албатай хамтран боловсруулж батлуулахыг Ахмадын зөвлөлийн тэргүүнд даалгасугай.
4. Зөвлөлийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 28-ны
өдрийн 82 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ
АХМАД ЗӨВЛӨХҮҮДИЙН ЗӨВЛӨЛ

№	Овог, нэр	Хүйс	Угасны дугаар	Хаана ажиллаж байсан
1	2	3	4	5
1	Чадраабалын Гомбодорж	Эр	96446777	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
2	Чулууны Амгалан	Эр	99447530	Санхүү хэлтсийн дарга
3	Цэрэнноровын Нарантуяа	Эм	89120915 99442444	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
4	Долгорын Сэр-Од	Эр	89132606	НҮГ дарга
5	Базаагийн Ядмаа	Эр	99447899	Шаргалжуут ЭХТ захирал
6	Тоохүүгийн Баасанжав	Эм	89182068	Эрдэнэмандал 3 дугаар сургуульд багш
7	Долгорын Доржсэмбээ	Эр	88185384	Нефть бааз инженер
8	Диваачомбын Дэмбэрэл	Эр	89447782	Сум, нэгдлийн дарга
9	Долгорын Шарав	Эр	99447099	Худалдааны нягтлан бодогч
10	Цагааны Адьяахорол	Эр	99750518	Захиалагчийн товчооны инженер
11	Ендонгийн Шийхар	Эр		Баялиг сумын намын дарга
12	Банзрагчийн Дагва	Эр	89440021	Эрдэнэцогт сумын намын дарга
13	Дамбын Балжинням	Эр	99447783	Аймгийн Цагдаагийн газар
14	Ламзавын Цэдэндамбаа	Эр	99065452	Аймгийн Шүүхийн дарга
15	Дамирангийн Баатаржав	Эр	99449478	Малын их эмч
16	Пагвын Санаадагва	Эр	99445212	Сэтгүүлч
17	Бүсийн Маам	Эр	89980433	Усны аж ахуй мэргэжилтэн
18	Доржийн Алгаа	Эр	99991878	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
19	Дэмчигийн Өлзий	Эр	88192504	Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
20	Мишигийн Балдорж	Эр	99708258	Аймгийн ЗДТГ-ын нярав
21	Түмэн-Өлзийн Пүрэвжав	Эр	99945061	Сум, нэгдлийн дарга
22	Доржийн Баасанхүү	Эм	99449200	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
23	Сүхбаатарын Лочинлхам	Эм	88448493	Баянхонгор сумын Засаг даргын орлогч
24	Шоонуугийн Гомбосүрэн	Эр	88445085	Баянхонгор сумын 1-р багийн Засаг дарга
25	Бямбын Дулмаа	Эм	99624168	Хүүхдийн эмч

1	2	3	4	5
26	Цэдэвийн Энэбиш	Эм		МХГ-ын мэргэжилтэн
27	Пүрэвийн Билэгт–Отгон	Эр	99449250	Баянхонгор сумын Ахмадын хорооны дарга
28	Жанцангийн Хасаг	Эр		Монгол Улсын аварга малчин
29	Түндэвийн Минжмаа	Эм	95789315	Хөдөө аж ахуй
30	Мөнхбаярын Мандах	Эр	99442299	Баянхонгор-Эрчим хүч ХХК-ний ерөнхий инженер
31	Дамбасүрэнгийн Хуулин	Эм	88086544	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн
32	Галсангийн Цэрэн	Эр	99449148	Дөрвөлжин бурам ХХК-ний захирал
33	Сүхбатын Бямбадорж	Эр	88117692	Өлзийт МСҮТ-ийн захирал

.....оо.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 83

Номгон

Орон сууц, гэр хорооллын
гудамжийг камержуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн хэмжээнд орон сууцны гадна орчин, гэр хорсоллын гудамж бүрийг иргэдийн өөрсдийнх нь хөрөнгөөр хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байрны хулгайн гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох зорилгоор гэрэлтүүлэг, теле хяналтын камерыг байрлуулсугай.

2. Хяналтын камер байрлуулах ажлыг зохион байгуулж, багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн саналын дагуу шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын камерын хүчин чадал, тавигдах шаардлагын дагуу Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт байрлах орон сууцны гадна орчин, гэр хорооллын гудамжинд теле хяналтын камер байрлуулах ажлыг зохион байгуулахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа /Б.Оюутболд/-д, Баянхонгор сумын багуудын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Баянхонгор сумын Засаг дарга, Ж.Төмөрбаатар нарт тус тус даалгасугай.

4. Гэрэлтүүлэг тавих, телекамер байрлуулах орон сууц, гэр хорооллын гудамжуудын нэрийг хавсралтаар тогтоосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D;2016-togtool2016

116729



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 84


Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2013 оны 57 дугаар тогтоолыг хүчингүй
болгох тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Хот тохижилт-Үйлчилгээ” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Харин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Хот тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг Баянхонгор сумын Засаг даргын удирдлагад шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн боловч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 65 дугаар тогтоолыг хүчингүй болгоогүй байна. Тогтоолуудыг цаг хугацааны хувьд авч үзвэл урд гарсан тогтоол нь хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд дараа нь гарсан тогтоол эрх зүйн үр дагавар үүсгэх боломжгүйг ТЭМДЭГЛЭЭД Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 57 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР